



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/471

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотод зохион байгуулагдах Хөлбөмбөгийн сонирхогчдын УАШТ, Ерөнхийлөгчийн нэрэмжит Үндэсний цом болон Эмэгтэйчүүдийн лигийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд оролцох тамирчдын замын зардалд 2 800 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Замын зардалд зарцуулагдах 2 800 000 төгрөг /Хоёр сая найман зуун мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/471 дүгээр захирамжийн хавсралт



ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ТАМИРЧДЫН ЗАРДАЛ

Д/д	Арга хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Давтамжийн тоо	Нийт үнэ
1	Тэмцээнд оролцох тамирчид	20	70000	2	2800000
	Нийт				2800000

-oOo-